




# ГЭРЭЛ ФИНАНС

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

## 2025 он

### Жилийн үйл ажиллагааны тайлан

#### ТАНЫ САНХҮҮГИЙН ГЭРЭЛ



# Компанийн танилцуулга

## Эрхэм зорилго

Харилцагчдад энгийн эрсдэлгүй, хүртээмжтэй, хэрэгцээнд зохицож, шаардлагад нийцсэн санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч санхүүгийн гэрэл - хөгжлийн түшиг байх болно.

## Алсын хараа

Бичил санхүүгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн, шуурхай үйлчилгээ, ёс зүй бүхий салбартаа тэргүүлэгч санхүүгийн байгууллага болно.

## Үнэт зүйлс

- Сэтгэл ханамжтай ажилтан
- Харилцагч төвтэй шинэлэг үйлчилгээ
- Ёс зүйтэй хамтын ажиллагаа
- Тогтвортой өндөр өгөөж

<b>Байгууллагын нэр</b>	<b>Гэрэл финанс ББСБ</b>
<b>Үйл ажиллагааны чиглэл</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Зээл</li> <li>• Итгэлцлийн үйлчилгээ</li> <li>• Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ</li> <li>• Финтек</li> </ul>
<b>Үйл ажиллагаа эхэлсэн огноо</b>	<b>2015.04.22</b>
<b>Салбарын тоо</b>	<b>3 салбар</b>
<b>Нийт хөрөнгийн хэмжээ</b>	<b>28.1 тэрбум төгрөг</b>
<b>Өөрийн хөрөнгийн хэмжээ</b>	<b>16.2 тэрбум төгрөг</b>
<b>Зээлийн багцын хэмжээ</b>	<b>26.2 тэрбум төгрөг</b>
<b>Финтек үйлчилгээний нэр</b>	<b>GEREL application</b>
<b>Gerel app бүртгэлтэй харилцагчдын тоо</b>	<b>246,798</b>



# Компанийн өсөлт /2025 он/


Хүндэт харилцагч, хөрөнгө оруулагч, хамтран ажиллагч байгууллага Та бүхэндээ 2025 оны үйл ажиллагааны тайланг танилцуулж байна. Өнгөрсөн онд бид технологийн дэвшлийг, уламжлалт санхүүгийн үйлчилгээтэй хослуулан Монгол улсын нийслэл Улаанбаатар хот болон 21 аймгийн төвийн харилцагчдадаа санхүүгийн үйлчилгээг үзүүллээ. 2025 онд бид 8.7 тэрбум төгрөгийн хүүгийн орлого олсноор, компанийн өөрийн хөрөнгө 50%-аар өсөж 16.2 тэрбум төгрөгт, нийт хөрөнгө 76%-аар өсөж 28.1 тэрбум төгрөгт хүрсэн амжилтыг үзүүллээ.

Нийт хөрөнгө /тэрбум төгрөгөөр/




**76%**

Өөрийн хөрөнгө /тэрбум төгрөгөөр/



**50%**


Хүүгийн орлого /тэрбум төгрөгөөр/



**51%**




# Зээлийн үйл ажиллагаа




Гэрэл финанс ББСБ нь финтек үйлчилгээний “GEREL” зээлийн аппликейшнаар дамжуулан Улаанбаатар хот болон 21 аймгийн төвийн харилцагчдад онлайн зээлийн үйлчилгээг, Улаанбаатар хотын 3 салбараар дамжуулан Улаанбаатар хотын харилцагчдад уламжлалт зээлийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

2025 онд Зохицуулах байгууллагын бодлого шийдвэрийг хангах болон харилцагчдын хэрэглээг илүү амар, ойлгомжтой болгох зорилгоор “GEREL” зээлийн аппликейшнд 2 удаагийн шинэчлэлийг хөгжүүлэн нэвтрүүлэв.

Цахилгаан барааны лизинг, автомашин, үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлийг шуурхай олгож, бизнесийн зээлийг шинээр нэвтрүүлэн ажилласнаар 2025 онд нийт зээлийн багцыг 80%-аар өсгөж 26.2 тэрбум төгрөгт хүрэв.



Зээлийн багц /тэрбум төгрөгөөр/



## Бонд, Итгэлцэл

Гэрэл финанс ББСБ нь 2021 оны 2 сард анхны 500 сая төгрөгийн бондыг, мөн 2021 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр Монголын Биржийн бус зах зээлийн хамгийн анхны бондыг гаргаж байсан, бондын зах зээлийн анхдагч, түүчээлэгч байгууллага юм. Өдгөө 2025 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар нийт 11 удаагийн бондыг амжилттай гаргаж, 11 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн байна. Үүнээс 6.5 тэрбум төгрөгийн бондыг хүүгийн хамт төлж хаасан байна.

Бид хөрөнгө оруулагчдад эрсдэл багатай, найдвартай өгөөж хүртээх зорилгоор 2025 онд Зээлийн удирдлага, Компанийн засаглалыг тасралтгүй сайжруулан ажиллалаа. Үүний үр дүнд 2023, 2024, 2025 онуудад Компанийн засаглалын үнэлгээгээр тэргүүлэгч ТОП 10 ББСБ-уудын нэгээр шалгарав.

2025 онд Гэрэл финанс ББСБ-ын Итгэлцлийн үйлчилгээний үлдэгдэл 2.2 дахин өсөж 5.2 тэрбум төгрөгт хүрэв.

2026 онд "GEREL" аппликейшнд хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнийг харилцагч нарынхаа хэрэгцээнд тулгуурлан уян хатан нөхцөлтэйгөөр хөгжүүлэн нэвтрүүлнэ. Ингэснээр бид харилцагч нарынхаа санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, өөртөө хөрөнгө оруулалтын зөв дадлыг бий болгоход ихээхэн хувь нэмэр үзүүлнэ гэсэн зорилготой байна.

### "Gerel Bond"-ын түүх

1	Огноо	Бонд нэр	Дүн	ҮЦК	Төлөв
2	2021.02.28	Gerel finance BOND	0,5 тэрбум	Апекс капитал ҮЦК	Төлөгдсөн
3	2021.08.09	Gerel finance BOND	0,5 тэрбум	Апекс капитал ҮЦК	Төлөгдсөн
4	2021.09.06	Gerel finance BOND	0,5 тэрбум	Апекс капитал ҮЦК	Төлөгдсөн
5	2022.03.28	Gerel finance BOND 1	0,5 тэрбум	Мандал капитал маркетс ҮЦК	Төлөгдсөн
6	2022.11.10	Gerel finance BOND 2	0,5 тэрбум	Апекс капитал ҮЦК	Төлөгдсөн
7	2023.12.20	Gerel finance BOND 3	2,0 тэрбум	Таван богд капитал ҮЦК	Төлөгдсөн
8	2024.12.06	Gerel finance BOND 4	2,0 тэрбум	Таван богд капитал ҮЦК	Төлөгдсөн
9	2025.01.13	Gerel finance BOND 5	1,5 тэрбум	Таван богд капитал ҮЦК	Идэвхитэй
10	2025.02.18	Gerel finance BOND 6	1,5 тэрбум	Таван богд капитал ҮЦК	Идэвхитэй
11	2025.12.11	Gerel finance BOND 7	1,5 тэрбум	Таван богд капитал ҮЦК	Идэвхитэй

### Итгэлцлийн үйлчилгээний үлдэгдэл



# Санхүүгийн тайлагнал

/сая төгрөгөөр/

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН	2023 он	2024 он	2025 он
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	668.06	408.17	842.12
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	8,115.56	14,489.96	26,023.53
БУСАД ХӨРӨНГӨ	245.01	67.37	144.06
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	479.17	930.80	999.01
БИЕТ БУС ХӨРӨНГӨ	111.87	114.72	112.07
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>	<b>9,619.67</b>	<b>16,011.02</b>	<b>28,120.79</b>
ЭХ ҮҮСВЭР	3,740.14	4,711.18	11,336.84
ӨР ТӨЛБӨР	247.97	528.49	591.37
ХУВЬЦААТ КАПИТАЛ	3,570.00	5,275.00	6,093.00
ХУРИМТЛАГДСАН АШИГ	2,050.96	5,485.75	9,540.10
БУСАД ӨМЧ	10.60	10.60	559.48
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БОЛОН ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>9,691.67</b>	<b>16,011.02</b>	<b>28,120.79</b>

/2025.12.31-ний байдлаар/

Зохистой харьцааны тайлан	Байвал зохих	Тайлан гаар	Хангасан эсэх
ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨГЛӨГ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	80%-аас хэтрэхгүй	32.2%	<b>ХАНГАСАН</b>
ӨРИЙН БИЧГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	30%-аас хэтрэхгүй	27.8%	<b>ХАНГАСАН</b>
ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	15%-аас хэтрэхгүй	3.6%	<b>ХАНГАСАН</b>
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, НИЙТ АКТИВЫН ХАРЬЦАА	30%-аас доошгүй	57.6%	<b>ХАНГАСАН</b>
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, ЭРСДЭЛЭЭР ЖИГНЭСЭН НИЙТ АКТИВЫН ХАРЬЦАА	20%-аас доошгүй	54.5%	<b>ХАНГАСАН</b>
НЭГ ЗЭЭЛДЭГЧ БОЛОН ХОЛБОГДОХ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛ, ЗЭЭЛТЭЙ АДИЛТГАН ТООЦОХ БУСАД АКТИВ ХӨРӨНГӨ, ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	30%-аас хэтрэхгүй	3.7%	<b>ХАНГАСАН</b>
ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА	8%-аас дээш	8.4%	<b>ХАНГАСАН</b>

# 2025 оны онцлох үйл явдлууд


- ГЭРЭЛ ФИНАНС ББСБ 10 НАС ХҮРЛЭЭ:**

2015 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооноос Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авснаар үйл ажиллагаагаа эхлүүлсэн түүхтэй. 2025 онд бидний 10 жилийн ой тохиосон түүхэн жил өнгөрлөө. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд орчин үеийн технологийн дэвшлийг уламжлалт санхүүгийн үйлчилгээтэй хослуулан иргэд, бичил, жижиг дунд бизнес эрхлэгчдэд санхүүгийн үйлчилгээг тасралтгүй хүргэн ажиллав. Үүний тод илрэл нь Гэрэл финанс ББСБ нь Монголын нийт ББСБ-ууд дундаас Шилдгийн шилдэг ББСБ-аар шалгарч “Алтан Од” шагнал хүртсэн үйл явдал юм.



- УРТ ЦАГААН САЛБАРААР УЛАМЖЛАЛТ ЗЭЭЛ ОЛГОЖ ЭХЭЛЛЭЭ:**

Уламжлалт зээлийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор финтек зээлийн эрсдэлийн салбар болох Урт цагаан салбараар 2025 оны 8 дугаар сараас эхлэн зээл олгож эхэллээ. Ингэснээр харилцагч өөрт ойр салбараараа үйлчлүүлэн зээл авах боломж нэгээр нэмэгдэж байна. 2025 онд чанаргүй зээл нийт зээлийн багцад эзлэх хувийг 5.9%-д барьж ажилласан нь салбарын дундаж чанаргүй зээлийн хувь хэмжээнээс бага түвшинд байна. Бид зээлийн багцын чанарыг сайжруулахад цаг үетэйгээ уялдсан шийдвэрүүдийг шуурхай гарган, онцгойлон анхаарч ажиллалаа.



- 7.5 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН GEREL FINANCE BOND ГАРГАХ ЗӨВШӨӨРӨЛ АВЛАА:**


Гэрэл финанс ББСБ нь 2026 онд Биржийн бус зах зээлд 7.5 тэрбум төгрөгийн Бонд гаргах зөвшөөрлийг Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны Биржийн бус зах зээлийн Бүртгэлийн хорооны 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн тогтоолоор 7.5 тэрбум төгрөгийн хаалттай “Gerel finance Bond 7” гаргах зөвшөөрөл авав. “Gerel finance Bond 7” бондын транч 1-ийг 2025 оны 12 дугаар сард гаргаж 1.5 тэрбум төгрөг татсан. Үлдсэн транчийг 2026 онд гаргахаар төлөвлөн ажиллаж байна.



- ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЛДЭГДЭЛ 2.2 ДАХИН ӨСӨВ:**

2025 онд 5.5 тэрбум төгрөгийн итгэлцэл шинээр татан төвлөрүүлж, 2 тэрбум төгрөгийн итгэлцэл хүүгийн хамт төлснөөр итгэлцлийн үйлчилгээний үлдэгдэл 5.2 тэрбум төгрөг болов. Энэ нь өмнөх оны мөн үеэс 2.2 дахин өссөн үзүүлэлт юм. Нийт итгэлцэл болон бондын хүүнд 2025 онд 975 сая төгрөгийг харилцагчдад олгосон байна.

2026 онд итгэлцлийн үйлчилгээгээр татсан хөрөнгийг бизнесийн зээлийг өргөжүүлэхэд чиглүүлж, бичил, жижиг дунд бизнес эрхлэгчдэд илүү уян хатан, таатай нөхцлөөр санхүүгийн үйлчилгээ үзүүлэхээр зорин ажиллаж байна



- ОЛОН УЛСАН СТАНДАРТЫГ АХИУЛАН БАТАЛГААЖУУЛАВ:**

2022, 2023, 2024 онуудад Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO/IEC 27001:2013 стандартыг байгууллагадаа хэрэгжүүлэн баталгаажуулж байсан бол 2025 онд тус стандартыг сайжруулан, ахиулан боловсруулсан шинэ олон улсын стандарт ISO/IEC 27001:2022 стандартыг шинээр нэвтрүүлэн хэрэгжүүлж Олон улсын сертификатаар батлагаажуулав. Ингэснээр “GEREL” зээлийн аппликейшн нь мэдээллийн аюулгүй байдлын шаардлагыг бүрэн ханган, харилцагчдынхаа хувийн болон санхүүгийн мэдээллийг олон улсын стандартын дагуу хамгаалж, уг тогтолцоог тасралтгүй сайжруулан ажиллаж байна.



Гэрэл аппликейшн  
**ISO 27001:2022 СТАНДАРТААР**  
 ШИНЭЧЛЭН БАТАЛГААЖЛАА


- **ШИЛДЭГ АЖИЛТНУУДЫН 10 ЖИЛИЙН ОЙН АЯЛАЛ:**

Гэрэл финанс ББСБ-ын амжилтын гол түлхүүр болсон, 10 жилийн түүхийг бичилцсэн шилдэг ажилтнууд 2025 оны 2 дугаар сард Тайланд улсын Пукет хотоор аялаж, мартагдашгүй дурсамжийг бүтээв. Үнэт зүйлс дотроо “Сэтгэл ханамжтай ажилтан” гэж тодорхойлсон Гэрэл финансчууд алхам бүртээ хөгжин, өсөн дэвшиж нэгэн онцгой хамт олны түүхийг бүтээсээр байна. Санхүүгийн зах зээлд ёс зүйтэй, шударга, шинэлэг, хэрэгцээнд зохицож, шаардлагад нийцэх үйлчилгээгээр ГЭРЭЛ нэмэн ажиллаж байгаа нийт ажилтан, хөрөнгө оруулагч, хамтран ажиллагсад та бүхэнд чин сэтгэлийн талархал илэрхийлье.




- **SANJAA” YOUTUBE СУВГИЙН “PODCAST ROOM” ПОДКАСТЫН ИВЭЭН ТЭТГЭГЧЭЭР АЖИЛЛАВ:**

Гэрэл финанс ББСБ-ын “GEREL” зээлийн аппликейшн нь нийгэмд шинэ өнгө төрх харуулан гарч ирсэн “Sanjaa” YouTube сувгийн “Podcast room” подкастын ивээн тэтгэгчээр 2025 онд ажиллав. 7 хоног бүр шинэ дугааруудыг бүтээж, түгжрэлийг түүлахад нэмэр болох, стрессийг бууруулахад дэм болох, хувь хүний хөгжил, амьдралын бодит асуудал болон өөрт хэрэгтэй мэдээллийг сонсож, өөрийгөө хөгжүүлэхэд бага ч болов тустай байсан гэдэгт итгэлтэй байна.



- **AMARJIN ПОДКАСТЫН ИВЭЭН ТЭТГЭГЧЭЭР АЖИЛЛАВ:**

Гэрэл финанс ББСБ-ын “GEREL” зээлийн аппликейшн нь мөн Саруул ухаант монголчууддаа зориулсан Amarjin подкастыг 2025 онд ивээн тэтгэж, дугаар бүр нь мэдлэг, мэдээллээр цалгиж байдаг подкастыг хамтран хүргэв. Тус подкастаар нийгэмд хийж бүтээсэн зүйлтэй, ярих юмтай, бодит туршлагатай зочдыг подкастандаа урьж оруулан хувь хүний хөгжил, санхүү, бизнес сэтгэлгээ, мэдлэг, зөвлөмжийг түгээх зорилготой ажиллав.



- **ВОЛЕЙБОЛЫН СПОРТЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИВ:**

Гэрэл Финанс ББСБ нь Монголын волейболын спортын хөгжилд бодит хувь нэмэр оруулах зорилгоор волейболын мэргэжлийн клуб болох **Mintonette Gobi Volleyball Club**-ын эрэгтэй, эмэгтэй багийг тус тус Silver Sponsor ивээн тэтгэгчээр хамтран ажиллаж байна. Ингэснээр бид санхүүгийн дэмжлэг үзүүлэн түүгээр дамжуулан тамирчдын хэрэгцээг хангахад мөн тус спортын хөгжилд шууд нөлөө үзүүлж байна. Волейболын спорт нь багийн уялдаа холбоо, хурдтай сэтгэх чадвар, нарийн техникт хамгийн их тулгуурладаг, үсрэлт, дамжуулалт, цохилтын хэмнэл чухал үүрэгтэй, мөн довтолгоо ба хамгаалалт маш хурдан солигддог учир бусад спортоос онцгой ялгардаг.

Бид цаашид ч спортын хөгжил, багаар ажиллах үнэ цэнийг үргэлж дэмжин ажиллах болно.





Шилдгийн шилдэг банк бус санхүүгийн байгууллагаар шалгарч АЛТ АН ОД шагнал хүртэв

# Анхаарал хандуулсан танд **БАЯРЛАЛАА**

 7717-4545

 [www.gerelfinance.com](http://www.gerelfinance.com)

 [info@gerelfinance.mn](mailto:info@gerelfinance.mn)